



ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖЭЭР АРИЛЖИГДСАН БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ТОДОРХОЙЛОЛТ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Хөдөө аж ахуйн биржээр арилжигдсан бараа, түүхий эдийн тодорхойлолтын маягт нь компанийн үнэт цаас бөгөөд зөвхөн Биржээр арилжигдсан бараа, бүтээгдэхүүний экспортын гаалийн бүрдүүлэлтэнд ашиглагдана.
- 1.2 Биржээр арилжигдсан бараа, түүхий эдийн тодорхойлолтын маягтыг үнэт цаас хэвлэх магадлан итгэмжлэгдсэн эрх бүхий хэвлэлийн компаниар хэвлүүлнэ.
- 1.3 Биржийн арилжаагаар худалдан авсан бараагаа экспортод гаргах тохиолдолд “Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хууль”-ийн 4.6, 5.1.4-т зааснаар энэхүү тодорхойлолтыг авна.
- 1.4 Журамд хэрэглэгдэх “Нэр томъёо”-г дараах байдлаар ойлгоно. Үүнд:
 - **“Биржээр арилжигдсан бараа, түүхий эдийн тодорхойлолт”** гэдэг нь биржийн арилжаагаар арилжигдсан бараа, бүтээгдэхүүний ангилал, нэр төрөл, боловсруулалт, хэмжээ, үнийн дүнг илэрхийлсэн биржийн албан ёсны баталгаа юм.
 - **“Тодорхойлолт хүсэгч”** гэдэг нь биржийн арилжаанд оролцсон худалдан авагч тал болох харилцагч байгууллага байна.
 - **“Үйлчилгээний хөлс”** гэдэг нь биржээр арилжигдсан бараа, түүхий эдийн тодорхойлолтын маягтын болон бараа, түүхий эдийн тодорхойлолт олгохтой холбоотой үйлчилгээний хөлсийг ойлгоно.

Хоёр. Биржээр арилжигдсан бараа, түүхий эдийн тодорхойлолтын маягт бүртгэх, хадгалах

- 2.1 Биржээр арилжигдсан бараа, түүхий эдийн тодорхойлолтын маягтын загварыг батлах, өөрчлөлт оруулах асуудлыг компанийн Захирлын зөвлөлөөр хэлэлцүүлж, Гүйцэтгэх захирал шийдвэр гаргана.
- 2.2 Батлагдсан загварын дагуу хэвлэгдсэн Биржээр арилжигдсан бараа, түүхий эдийн тодорхойлолтын маягтыг Ерөнхий нягтлан бодогч тоо ёсоор хүлээн авч бүртгэл хөтлөх ба маягт нь компанийн үнэт цаас болохын хувьд ажлын байранд найдвартай хадгалагдана.

